

АНАГААХ УХААНЫ УДАМЗҮЙН ДАДЛАГЫН ХИЧЭЭЛД УЛАМЖЛАЛТ БОЛОН АСУУДАЛД СУУРИЛСАН СУРГАЛТЫН АРГАЗҮЙГ ХАРЬЦУУЛСАН ДҮН

Ц.Алтансүх¹, Б.Цэрэндолгор²
 1-Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль
 2-Эм зүйн шинжлэх ухааны их сургууль
 И-шуудан: altansukh.ts@mnums.edu.mn

COMPARISON STUDY ON APPLICATION OF TRADITIONAL AND PROBLEM-BASED LEARNING METHODS IN TEACHING MEDICAL GENETICS

Altansukh Ts¹, Tserendolgor B²
 1-Mongolian National University of Medical Sciences
 2-University of Pharmaceutical Sciences

Abstract

Introduction: In the current time, the information on medical sciences is in a huge increase due to focused researches in medicine to expand knowledge. Although there are a lot of knowledge in medicine, it is urgently required to introduce new teaching methods for medical students.

Aim: We have applied the method “Problem-based learning” to compare to traditional teaching method in medical genetics.

Method: In the study, 22 students in 2 groups were participated and the data were collected by using external evaluation, student grades and questionnaire.

Results: According to the result, the student participation was evaluated as good and excellent in 82% of PBL-taught group. Moreover, the student grades were “A” and “B” marked in 82% of PBL-taught group. Finally, the result showed that the students’ satisfaction of PBL-taught group to medical genetics was found as 100%.

Conclusion: Taking together, those results suggested that the method “Problem-based learning” might be an effective tool to teach medical genetics for students.

Key words: Medical genetics, Problem-based learning, practice

Судалгааны ажлын үндэслэл

Монголын Анагаах ухааны боловсролын тогтолцоонд багшийн заах аргазүйг сайжруулах, оюутанд хүрэх мэдлэгийн нийгэм дэх бодит хэрэгцээг таниулах, нэмэгдүүлэх чиглэлээр 2000 оноос хойш багагүй ажлууд хийгдсээр байгаа юм. Үүнтэй уялдан асуудалд суурилсан, амьдралд суурилсан сургалтын аргыг Анагаахын мэргэжлийн хичээлүүдэд ашиглаж эхлээд байна¹⁻².

Анагаах ухааны удамзүйн (АУУ) хичээл нь оюутанд аливаа өвчний удамшлын шалтгааныг тайлбарлах, удамшлын хэлбэртэй нь уялдуулан оношлогоо, эмчилгээ, цаашдын

тавиланг таамаглах боломжийг олгодог чухал мэргэжлийн суурь хичээлүүдийн нэг юм³. Анагаах ухааны сургуулиудад АУУ хичээлийг уламжлалт аргаар буюу багш тайлбарлах, дадлагыг биечлэн удирдах хэлбэрээр зохион байгуулдаг. Ийм хэлбэр нь оюутны бие даан ажиллах чадвар, анагаах ухааны удамзүйн хичээлийн нийгмийн хэрэгцээг ухаарахад дутагдалтай байж болох юм⁴.

Харин анагаах ухааны удамзүй хичээлд асуудалд суурилсан сургалтын аргазүйг хэрэглэснээр хичээлийн нийгмийн бодит хэрэгцээг танин мэдэх, асуудлыг задлан шинжилж, боломжийг эрж хайх, цаашлаад

асуудлыг шийдвэрлэхэд илүү дөхөмтэй байж болох талтай¹.

Энэхүү судалгаагаар бид асуудалд суурилсан сургалтын аргазүйг анагаах ухааны удамзүй хичээлийн заах аргазүйд туршин ашиглах зорилго тавьсан юм.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүллээ.

1. Уламжлалт болон асуудалд суурилсан сургалтын аргазүйг оюутны хичээлд оролцож буй идэвх болон хичээлийн эцсийн дүнгээр харьцуулан үнэлэх
2. Сургалтын заах аргазүйн хэлбэрүүдэд оюутны сэтгэл ханамжийг харьцуулах

Судалгааны хэрэглэгдэхүүн ба аргазүй

Судалгаа нь бүлгийн судалгааны хэлбэрт хамаарах бөгөөд 2018 оны 5-р сард Био-Анагаахын 3-р дамжааны 2 бүлгийн нийт 22 оюутнуудыг хамрууллаа.

Оюутны идэвхийг үнэлгээний хуудсаар үнэлсэн бөгөөд идэвхийг муу, дунд, сайн, маш сайн гэж тэмдэглэн дүгнэлээ. Харин оюутны

хичээлийн эцсийн дүнг уламжлалт сургалтын хэлбэрийн хувьд тестээр үнэлсэн бол, асуудалд суурилсан сургатын хувьд тодорхой асуудалд дүн шинжилгээ хийсэн байдалд үнэлгээ өгч үнэлсэн болно. Сургалтын заах аргазүйн хэлбэрүүдэд оюутны сэтгэл ханамжийг асуумжаар үнэллээ.

Статистик боловсруулалт: Судалгааны үр дүнг Microsoft Excel 2010 программыг ашиглан гүйцэтгэлээ.

Судалгааны ажлын үр дүн

Бид судалгаандаа Био-Анагаахын 3-р дамжааны 22 оюутныг хамруулан хичээлийн оролцооны идэвхийг харьцуулан тодорхойлоход уламжлалт аргаар суралцаж буй оюутнуудын 4 (37%) нь хичээлд оролцох идэвх сайн, маш сайн гэсэн ангилалд хамаарч байгаа бол, асуудалд суурилсан сургалтанд хамрагдсан оюутнуудын 9 (82%) нь хичээлд оролцох идэвх сайн ба маш сайн ангилалд хамаарч байлаа (Table 1).

Table 1.

Comparison of student participation on evaluating traditional and problem-based learning methodsaa

Student participation	Traditional method (students' number)	Problem-based learning (students' number)
Poor	3 (27%)	1 (9%)
Fair	4 (37%)	1 (9%)
Good	2 (18%)	5 (45%)
Excellent	2 (18%)	4 (37%)
Total	n=11	n=11

Судалгаанд хамрагдсан оюутнуудын хичээлийн дүнг харьцуулан 2 бүлэгт судлахад уламжлалт заах аргазүйгээр суралцаж буй оюутнуудын 2 нь буюу 18% нь “B”-ээс дээш үнэлгээтэй бол, асуудалд суурилсан сургалтаар суралцаж буй оюутнуудын дийлэнх нь буюу 82% нь “B”-ээс дээш үнэлэгджээ

(Table 2).

Дүгнэлт:

1. Асуудалд суурилсан сургалтаар суралцагчдын 82% нь хичээлийн идэвх сайн, маш сайн үнэлгээтэй байсан бол, мөн бүлгийн оюутнуудын 82% нь “В” ба “А” гэсэн үнэлгээ авлаа.
2. Уламжлалт заах аргазүйгээр суралцаж буй оюутнуудын 74% нь, асуудалд суурилсан сургалтын хэлбэрээр суралцаж буй бүх оюутнууд нь дунд ба түүнээс дээш сэтгэл ханамжтай байна.

Номзүй

1. Moore CM, Barnett DR. A problem-based learning approach to teaching medical genetics. American journal of human genetics. 1992;51(4):930.
2. CHEN F-j, LI C-y, SUN X-j, FU W-n, JIN C-l, ZHAO Y-y. Exploration into PBL Teaching Pattern in Medical Genetics Teaching [J]. Northwest Medical Education. 2008;2:054.
3. Maradiegue A, Edwards QT, Seibert D, Macri C, Sitzler L. Knowledge, perceptions, and attitudes of advanced practice nursing students regarding medical genetics. Journal of the American Academy of Nurse Practitioners. 2005;17(11):472-9.
4. Abdel Meguid E, Collins M. Students' perceptions of lecturing approaches: traditional versus interactive teaching. Advances in medical education and practice. 2017;8:229-41.
5. Zhang Y, Zhou L, Liu X, Liu L, Wu Y, Zhao Z, et al. The effectiveness of the problem-based learning teaching model for use in introductory Chinese undergraduate medical courses: a systematic review and meta-analysis. PLoS one. 2015;10(3):e0120884.
6. Imanieh MH, Dehghani SM, Sobhani AR, Haghighat M. Evaluation of prob-

lem-based learning in medical students' education. Journal of advances in medical education & professionalism. 2014;2(1):1-5.

7. Dolmans D, Schmidt H. The advantages of problem-based curricula. Postgraduate medical journal. 1996;72(851):535-8.

*Уншин танилцаж, нийтлэх санал өгсөн:
ЭЗУ-ы доктор, дэд профессор Л.Уламбаяр*